



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 08 өдөр

Дугаар А/550

Есөнбулаг сум

Журам боловсруулан мөрдөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5 дахь заалт, Боловсролын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 6 дахь заалт, 30 дугаар зүйлийн 1.11 дэх заалт, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.11 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамирын заалыг зөвхөн сурагчдын хичээл сургалтын үйл ажиллагаа, уралдаан тэмцээнд бэлтгэх, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, биеийн тамир, спортын мэдлэг, дадлыг төлөвшүүлэх зорилгоор ашиглах бөгөөд бусад хувь хүн, байгууллагад орлого олох байдлаар ашиглуулахгүй байх зохицуулалтыг хийж, холбогдох журмыг боловсруулан хэрэгжүүлж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг), Боловсролын газар (Д.Энхцэцэг)-т тус тус үүрэг болгосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Д.Буянхишиг), Нийгмийн бодлогын хэлтэс (Ж.Амгаланбаатар)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

